




Grand
Сугалаа™



ГРАНД
СИСТЕМС

МӨРӨӨДЛӨӨ
БИЕЛҮҮЛ

ХУРЛЫН МАТЕРИАЛ



СУГАЛАА АВАХ:

WWW.GRANDLOTTO.MN



АГУУЛГА

ХУРЛЫН ЗАР _____	3
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ _____	4
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ _____	6
КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА _____	8
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ _____	11
ХАВСРАЛТ 1. САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР _____	12
ХАВСРАЛТ 2. ТОГТООЛЫН ТӨСӨЛ _____	13

ХУРЛЫН ЗАР

"ГРАНД СИСТЕМС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Гранд Системс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 16-ны өдрийн тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлаж байна.

ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ГАЗАР: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржав гудамж 9, Ориент Плаза хаяг, 1 давхар, хурлын өрөө

ХУГАЦАА: 2026 оны 04 сарын 27-ны өдрийн 09:00 цагт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОНООСОН НЭР: “ГРАНД СИСТЕМС” ХК

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2026 оны 04 сарын 07-ны өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл, хавсралт;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал;

Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд 9:00–18:00 цагийн хооронд доорх холбоо барих мэдээллийн дагуу хандаж хурлын материал, саналын хуудастай танилцах боломжтой.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, 503 тоот;

Имэйл хаяг: info@grandlotto.mn;

Утас: 94545057, 72279292

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол саналын хуудсаар урьдчилан саналаа дээр дурдсан хаягаар “Гранд Системс” ХК-д шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2026 оны 04 сарын 24-ны өдрийн 16:00 цаг байна.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

“ГРАНД СИСТЕМС” ХК

2026 оны 03 сарын 16

№ 26/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Компанийн дүрмийн 8.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Гранд Системс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Гранд Системс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 04 сарын 27-ны өдрийн 09:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржав гудамж 9, Ориент Плаза, 1 давхарт хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2026 оны 03 сарын 19-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 сарын 20-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2026 оны 04 сарын 03-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2026 оны 03 сарын 25-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2026 оны 04 сарын 24-ний өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Батмөнх овогтой Баярмаа томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:

“ГРАНД СИСТЕМС” ХК

“Гранд Системс” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Энхбилэг
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
“Гранд Системс” ХК-ийн дэд захирал Э.Тэнүүн
“Гранд Системс” ХК-ийн ерөнхий менежер Б.Баярмаа

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Үүнд:
Тооллогын комиссын дарга:
Г.Алтансүх
Тооллогын комиссын гишүүд:
М.Баярчимэг
Ж.Байгальмаа
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ө.БОЛД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

(Хурал үргэлжлэх хугацаа 2 цаг)

№	Хуваарь	Хариуцах тал	Цаг
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/;	Тооллогын комисс	15 минут
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/;		
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	Хурлын дарга	5 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах 1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах; 2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;	Хурлын дарга	30 минут
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт	Тооллогын комисс	10 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;	Тооллогын комисс	10 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	Хурлын дарга	5 минут
8	Хурлыг хаах		5 минут

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;

--o0o--

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр	Гранд Системс ХК
Хуулийн этгээдийн улсын бүртгэл	УБД: 9011779001 РД: 6371477
Үйл ажиллагааны чиглэл	- Программ хангамжийн үйлчилгээ - Мэдээлэл технологийн үйл ажиллагаа - Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах
Санхүүгийн үзүүлэлт /2025.12.31/	Хөрөнгө: 1.6 тэрбум төгрөг Өмч: 0.6 тэрбум төгрөг Өр төлбөр: 1.0 тэрбум төгрөг
Гүйцэтгэх захирал	Д.Энхбилэг
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар, 1 хороо, 13, Нарны зам 62, 503 тоот Утас: 976-94545057 И-мэйл: info@grandlotto.mn

Гранд Системс нь 2018 онд байгуулагдсан Сангийн Яамны тусгай зөвшөөрөлтэй сугалааны компани юм. Компани нь үндэсний томоохон үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор сугалаа зохион байгуулдаг.

Гранд Системс нь 2024 онд МХБ-д бүртгүүлж, олон нийтэд хувьцаагаа амжилттай санал болгосноор анхны сугалааны ХУВЬЦААТ КОМПАНИ болсон.

Гранд Системс нь 2025 онд 121 удаа сугалаа болон урамшуулалт аяны тохирол явуулж, 111 мянган харилцагчтай болсон байна.

Хувьцаа эзэмшигч

2025 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь нийт 3,750,000 ширхэг хувьцаатай байгаа бөгөөд үүнээс 2 байгууллага болон хувь хүн нийт хувьцааны 5%-аас дээш хувийг эзэмшиж байна.

Компанийн 5%-аас дээш хувьцаа эзэмшигчид (2025.12.31):

	Нэр	Тоо	Хувь
1	Баялаг Хонд ХХК	2,670,000.00	71.2%
2	Н.Сүрэнхорлоо	300,000.00	8.0%
3	Бусад	780,000.00	20.8%
	Нийт	3,750,000.00	100%

Ногдол ашиг

Гранд Системс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №26/01 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргасан болно.

Санхүүгийн тайлан

Гранд Системс ХК нь 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 1.2 тэрбум төгрөг орлоготой, 44.7 сая төгрөгийн ашигтай байна. Компани нь МХБ-д бүртгүүлж, хувьцаат компани болсон, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн нь ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

Баланс (урьдчилсан

/2025.12.31 төгрөгөөр/

Балансын зүйл	Үлдэгдэл	
	1-р сарын 1	12-р сарын 31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	360,815,982	652,408,985
Дансны авлага	211,174,464	211,174,464
Татвар НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	1,150,300	249,806,300
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	13,000,000	809,400
Эргэлтийн хөрөнгийн дүн	586,140,746	1,114,199,149
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	28,469,676	48,684,091
Биет бус хөрөнгө	371,921,818	412,830,909
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	400,391,494	461,515,001
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	986,532,240	1,575,714,149
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	675,010,890	170,615,172
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	22,781,783	118,351,819
НДШ-ийн өглөг	10,899,347	4,655,509
Бусад богино хугацаат өр төлбөр	-	319,984,606
Богино хугацаат өр төлбөрийн дүн	708,692,020	613,607,105
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	708,692,020	613,607,105
Эзэмшигчдийн өмч		
Өмч:		
-Төрийн өмч		
-Хувийн өмч	300,000,000	375,000,000
-Хувьцаат		
Халаасны хувьцаа		35,456,700
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	600,000,000
Хуримтлагдсан ашиг алдагдал	(22,159,780)	22,563,744
Тайлант үеийн		44,723,524
Өмнөх үеийн	(22,159,780)	(22,159,780)
Эзэмшигчдийн өмчийн дүн	277,840,220	962,107,044
Цөөнхийн хувь оролцоо		
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	986,532,240	1,575,714,149

Орлогын тайлан (урьдчилсан)

/2025.12.31 төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант хугацааны дүн
Борлуулалтын орлого (цэвэр)	1,210,697,303
Борлуулсан барааны өртөг	-
Нийт ашиг (алдагдал)	1,210,697,303
Ерөнхий ба удирдлагын зардал	1,160,075,931
Санхүүгийн зардал	428,567
Бусад ашиг (алдагдал)	(500,000)
Татварын өмнөх ашиг (алдагдал)	49,692,804
Орлогын татварын зардал	4,969,280
Татварын дараах ашиг (алдагдал)	44,723,524
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	44,723,524
Бусад дэлгэрэнгүй орлого	-

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;

Компани нь 2024 оны сүүлээр анх удаа өөрийн нэрээр олон нийтэд сугалаа явуулж эхэлсэн билээ. 2024 онд 7 удаа сугалаа болон урамшуулалт аяны тохирол явуулсан бол 2025 онд 121 удаа сугалаа болон урамшуулалт аяны тохирлыг явуулсан.

Компани нь 2024 оны эхээр 3,278 харилцагчтай байсан бол жилийн эцсээр нийт 111 мянга гаруй (давхардаагүй) тоглогч сугалаанд оролцсон байна.

Санхүүгийн байдлын хувьд Компани нь жилийн эцсийн байдлаар 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 0.6 тэрбум төгрөгийн өр төлбөртэй, 1.0 тэрбум төгрөгийн эздийн өмчтэй байна. Орлогын хувьд 1.2 тэрбум төгрөг, 44.7 сая төгрөгийн ашигтай ажилласан. Компани нь МХБ-д бүртгүүлж, хувьцаат компани болсон, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн нь ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;

Компанийн жилийн санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Баталгаат Тооцоолол Аудит ХХК аудит хийж байна. Аудитын тайланг Аудитын тухай хуульд заасан хугацаанд гаргуулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулах болно.

ХАВСРАЛТ 1. САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 03 сарын 16-ны өдрийн
..... ТООТ тогтоолын Хавсралт 3

“ГРАНД СИСТЕМС” ХК САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 04 сарын 27-ны өдрийн 09:00 цагт хуралдах “Гранд Системс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн **ээлжит хуралд** санал өгнө.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай				
2	Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх	Хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай				

Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Компанийн хаягаар очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____
Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны сарын..... өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _____ / _____
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

ХАВСРАЛТ 2. ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“ГРАНД СИСТЕМС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27-ны өдөр

№

Улаанбаатар хот

ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн “ГРАНД СИСТЕМС” ХК (“Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны Санхүүгийн болон Үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРМАА

**“ГРАНД СИСТЕМС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 27-ны өдөр

№

Улаанбаатар хот

**ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн “ГРАНД СИСТЕМС” ХК (“**Компани**” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдйн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРМАА